

УВС АЙМГИЙН АРХИВЫН ТАСАГ

Увс аймгийн архив 1958 онд байгуулагдсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн Архивын тасаг.



Зохион байгуулалтын нэгжийн нэр	Албан тушаал	Орон тоо
Архивын тасаг	Тасгийн дарга	1
	Сан хөмрөгийн эрхлэгч	1
	Гэрээт архивч	5
Нийт		7

Сан хөмрөг:


Сан хөмрөг үүсгэгчийн нийт тоо 202. Үүнээс: Төрийн байгууллага 184, Төрийн өмч оролцсон аж ахуйн нэгж 8, Улс төрийн нам 1, Олон нийтийн байгууллага 2, Төрийн бус бусалт байгууллага 4, Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж 3. Хөмрөгийн нийт тоо 180. Хадгалагдаж буй баримтын тоо хэмжээ 202. Хөмрөг үүсгэгч байгууллагын 48869 хадгаламжийн нэгж. 2,864,071 хуудас.

Баримтын төрөл	Он цаг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт дүн	Тайлбар
Цаасан суурьтай баримт	1938-2011	Хуудсаар	2834371	2834371	
Зураг төслийн баримт	1970-2011	Хуудсаар	29700	29700	


Увс аймгийн архивт Увс аймгийг удирдах болон тухайн үеийн төр засгийн дээд байгууллагаас авч хэрэгжүүлж байсан арга хэмжээ, баримталж байсан бодлого, зорилтыг илтгэсэн олон ховор нандин, үнэт баримт байдагаас гадна 1938-2005 оны хоорондох Увс аймагт үйл ажиллагаагаа явуулж байсан өдгөө татан буугдсан ба үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалт, хамрах хүрээ нь өөрчлөгдөн өнөө үе хүртэл үйл ажиллагаагаа явуулж буй төр ба олон нийтийн байгууллагуудын түүх хадгалагдаж байна.



Аймгийн ХЗЭ-ийн хорооны XVII бага хурал




Аймгийн шүүхийн баримт “Онц ноцтой хэргээс 1930 он”



1932 оны 1-р бүгд хурлын тогтоолууд, намын хорооны ерөнхий илтгэл, хамтарлын тухай, үйлдвэрчний товчооноос ажилчин зарц нарын тухай явуулсан ажлын мэдээ.



Тэргүүний малчин сонинд аймгийн алдар цуутангуудын түүхэн замналаас Увс аймгийн Малчин сумын харьяат Улсын заан Ө.Тулгаа болон аймгийн алдар цуутнууд



1938 оны хувьсгалын эсэргүү нараас хураагдсан хөрөнгийг орон нутгийн хүмүүст зээлээр олгосон баримт.

Хаяг:

Увс аймаг Улаангом хот, 5 дугаар баг, Маршал Ю.Цэдэнбалын гудамж, 5 дугаар байр, 201-203 тоот өрөө

Цахим шуудан: uvs@archives.gov.mn

Харилцах утасны дугаар:

Архивын тасаг: 70454177

Факс: 70454095